



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 09 өдөр

Дугаар

1128

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа  
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалынхоёрдугаар хавсралтад дурьдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурьдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

6. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.


ДАРГА

Э.БАТТУЛГА



1150500086

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2014 оны 5 сарын 09  
өдрийн тоот тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2014.05.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Нэгдэлч ХХК	Нэгдэлчин	Баянзүрх дүүрэг, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 33/1

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2014 оны 15 сарын 09  
өдрийн 128 тоот тушаалын хоёрдугаар  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ  
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2014.05.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Зүүн баян рефайнери ХХК	Пийс бридж	Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Дунд гол гудамж-47
2	Кондитер Улаанбаатар ХХК	Шинэ Алтай	Сонгинохайрхан дүүрэг, 18-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 28
3	Ой мод ХХК	Хараа	Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Чоймболын гудамж 6
4	ЭБ 3 ХХК	Амарбаясгалант	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 15а/5
5	Цоглог хангай ХХК	Титэм	Сонгинохайрхан дүүрэг, 14-р хороо, Залуус гудамж

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2014 оны 05 сарын 09  
өдрийн 168 тоот тушаалын гуравдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН  
ЖАГСААЛТ

2014.05.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Ж.Батхүү	Баян	Чингэлтэй дүүрэг, 12-р хороо, Булгийн 2/174а
2	Вайт Анжел ХХК	Анжел	Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Чоймболын гудамж 6
3	Трикаларс треже ХХК	Гурван өнгө	Баянгол дүүрэг, 6-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө 76/2

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 05 сарын 09 өдрийн  
А/д/Б тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ  
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2014.05.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Цорс буянт ХХК	Аэро	Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Морингийн зам 33

-ooOoo-